

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-5

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	4-5
--	------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Т.Аубакир, Г.Ганбаатар, С.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Лүндэг, М.Мандхай, Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Б.Найдалаа, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: Р.Сэддорж.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ уг асуудлыг хойшлуулах тухай горимын санал гаргав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	11
Татгалзсан	2
Бүгд	13

84.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр,
Даваагараг Төрийн ордон “Их засаг” танхимд 14 цаг 55 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: За эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 54.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

За хуралдааны ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар ирсэн байна. Жигжидийн Батжаргал ирсэн байна, Сонгобайн Замира ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Жигжидийн Чинбүрэн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Лувсанбямбын Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Болдын Уянгаа гишүүн ирсэн байна аа.

За хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Асуудалтай холбоотой. За Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээний тухай хуулиар санал ерөөсөө аваагүй байна. За ер нь болбол хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдээс огт санал аваагүй байна. Орон нутгийн иргэдээс огт санал аваагүй байна. Энэ яаман дээр тодорхой хэмжээнд боловсруулах түвшинд бол бас тодорхой санхүүжилтийн асуудлыг нь Дэлхийн банкнаас авхуулаад нэг ганц хоёр газруудтай яриад шийдээд явчихсан юм байна. Энэ дээр бол нэлээн олон асуудлууд хөндөгдөх ёстой гэж харж байгаа.

Одоогийн байгаагаар болбол Улсын Их Хурлаар хэлэлцэхийг нь дэмжсэн. Гэхдээ тэрэн дотор хөндөгдөөгүй асуудлыг бид нар хөндөх боломжгүй байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ ажлын хэсэг байгуулахыг Улсын Их Хурлын одоо бас дарга бусад гишүүдтэй ярьсны хүрээнд Улсын Их Хурлын гишүүдээс өргөн бариад, ажлын хэсгээ дараа нь яг тэр түвшинтэйгээ зэрэгцэж байгуулаад, тэгээд хоёр талаасаа бодлогыг нь нийлүүлээд нэг болгоод явъя аа гэдэг ийм байр суурьтай байгаа. Тэгэхээр энэ удаагийн асуудлыг хойшлуулж өгөөч ээ гэсэн саналтай байгаа.

Б.Бейсен: За Бат-Өлзий гишүүн горимын санал гаргасан учраас энэ хойшлуулж өгье гээд ярьсан. Булгантуяа гишүүн бас түрүүн даргын дэргэдэх зөвлөлийн хурал дээр бас ярьж байсан. Энэ ажлын хэсэг хууль өргөн барьж байгаа гишүүд байгаа. Тэгээд нэгтгээд байгуулаагүй байсан гээд ярьсан. Тэгэхдээ энэ бид нар нөгөө юуны төлөвлөгөөний дагуу ажлын хэсэг юунд хэлэлцэх асуудлын юунд оруулчихсан байсан.

Тэгэхээр энэ Бат-Эрдэнэ гишүүний юугаар санал хураалт явуулъя. Хойшлуулах. За горимын саналаар санал хураалт. Санал хураалтдаа бэлтгээрэй. Санал хураалт.

Саналын томъёолол 84.6 хувьд дэмжигдсэн тул энэ хэлэлцэх асуудлаа хойшлуулъя.

Ирсэн гишүүдэд баярлалаа. Өнөөдрийн хуралдаан дууссаныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ